

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГА, ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААГ САЙЖРУУЛАХ АРГА ЗАМ

Э.Одбаяр

Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн 8021 дүгээр дамжааны суралцагч

Товч агуулга: Энэхүү илтгэлийн зорилго цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд ил тод сурталчлах, гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажилд олон нийтийн дэмжлэг тусалцааг өргөнөөр авах зайлшгүй шаардлага бий болсныг харуулж байгаа хэрэг бөгөөд үүнд хэвлэл, мэдээллийн хэрэгслийн үүрэг асар их юм. Энэ нь цагдаагийн байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах зайлшгүй шаардлага бий болсныг нотолж байгаа хэрэг бөгөөд цаашид энэ чиглэлээр судалгаанд суурилсан, бодит ажлыг хэрэгжүүлэх шаардлага бий болсныг харуулахыг зорилоо.

Abstract: This article's purpose is to demonstrate the urgent need to promote police activities to the public and to obtain broad public support in the fight against and prevention of crime. The role of the media in this is enormous. This confirms the urgent need to improve cooperation between the police and the media and aims to demonstrate the need for further research-based and practical work in this area.

Түлхүүр үгс: Цагдаагийн байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллага, хамтын ажиллагаа, сөрөг мэдээлэл.

Keywords: Police organizations, media organizations, cooperation, negative information.

Оршил

Монгол Улс 1992 онд анх удаа ардчилсан Үндсэн хуулиа баталж, энэхүү хуулийн хүний эрх, эрх чөлөө бүлгийн 16 дугаар зүйлийн 16-д “Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй”, 17-д “Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд,

улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална” гэж заасан¹.

Манай улсын хөгжлийн түүхэн явцаас товч дүгнэвэл мэдээллийн хувьд харьцангуй хаалттай байсан өмнөх нийгмээс ардчилсан, чөлөөт эдийн засгийн нийгэмд шилжсэн цаг үеэс хүн бүрийн үзэл, бодлоо чөлөөтэй

¹ Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. 1992. №1.

илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөө нээгдсэн нь нийгмийн оюун санаанд гарсан томоохон хувьсгалт эргэлт болсон төдийгүй мэдээллийн шинэ эрэн зууны үе эхэлсэн гэж үзэж болно.

Олон хэвшлийн хэвлэл, мэдээллийн байгууллагууд үүсч цагдаагийн байгууллагаас тэдгээртэй харилцаатай байж гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам хамгаалах чиглэлээр болон албаны үйл ажиллагаа, алба хаагчаа сурталчлах зэргээр өргөн хүрээнд хамтран ажилласаар байна.

Цагдаагийн байгууллагын хөгжлийн түүхээс дүгнэхэд эхэн үедээ хэвлэл мэдээлэл хариуцсан нэг албан тушаалтан ажиллаж цаг үеийн шаардлагаар энэ нь өнөөгийн Хэвлэл мэдээллийн төв болтлоо өргөжин үйл ажиллагаагаа явуулсаар байгаа нь нэг талаас цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй сурталчлах, нөгөө талаас хэвлэл, мэдээллийн байгууллагаар дамжуулан хуулиар хүлээсэн гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргээ хэрэгжүүлэхдээ иргэд, олон нийтийн дэмжлэг, туслалцааг авах боломжийг бүрдүүлж байгаа нь чухал ач холбогдолтой юм.

Түүнчлэн цагдаагийн албаны болон алба хаагчийн үйл ажиллагаатай холбоотой сөрөг мэдээлэл цахим болон хэвлэл, мэдээллийн хэрэгслээр байнга цацагдаж, эдгээр нь цагдаагийн байгууллага, алба хаагчийн нэр хүндэд нөлөөлж байгаад дүгнэлт хийж албаны нэр хүндийг өсгөх, албаараа бахархах сэтгэлийг төрүүлэх шинэлэг ажлыг хийх шаардлага бий болсоор байгаа нь судалгаагаар нотлогдож байна¹.

2021-2024 онд цагдаагийн байгууллагын алба хаагчтай холбоотой өргөдөл, гомдол нийт 9671-г хүлээн авч, 10849 алба хаагч, ажилтанд холбогдуулан шалгасны 8791 буюу 81.1 хувийг офицер, 2046 буюу 18.8 хувийг ахлагч, 12 буюу 0.1 хувийг энгийн ажилтан тус тус эзэлж байна. Дээрх өргөдөл, гомдлыг төрлөөр нь авч үзвэл 906 буюу 9.3 хувь нь хууль ёс, хүний эрх чөлөө зөрчсөн, 1884 буюу 19.4 хувь нь хэрэг материал дутуу шалгасан, 257 буюу 2.6 хувь нь хэргийн хугацаа хэтэрсэн, 591 буюу 6.1 хувь нь бусдыг чирэгдүүлж, танил тал харсан, 92 буюу 0.9 хувь нь хээл хахууль, шан харамж авсан, 2235 буюу 23.1 хувь нь цагдаагийн алба хаагчийн харьцааны соёл, ёс зүй зөрчсөн, 308 буюу 3.1 хувь нь бусдыг зодож, эрх чөлөөнд нь халдсан, 1249 буюу 12.9 хувь нь ажлын

¹ Цагдаагийн байгууллага, алба хаагчийн талаар 1 сарын хугацаанд өдөр тутмын хэвлэл, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр цацсан мэдээлэлд дүн шинжилгээ хийхэд, нийт 111 мэдээлэл нийтлэгдсэнээс сөрөг мэдээлэл 40 буюу 36,0 хувь, эерэг мэдээлэл 45 буюу 40,5 хувь, үйл ажиллагаатай холбоотой энгийн мэдээлэл 11 буюу 9,9 хувь, цагдаагийн байгууллагаас сөрөг мэдээлэлд хариу

тайлбар хийсэн нь 15 буюу 13,5 хувийг эзэлж байна. Үүнээс дүгнэвэл цагдаагийн байгууллага сөрөг мэдээлэлд албан ёсны байр сууриа тэр бүр илэрхийлдэггүй нь тогтоогдож энэ нь эргээд цагдаагийн албаны нэр хүндэд сөргөөр нөлөөлж цагдаагийн байгууллагад итгэх иргэд, олон нийтийн итгэл буурч байгаагийн нэг үзүүлэлт юм.

хариуцлага алдсан, 211 буюу 2.1 хувь нь архидаан согтуурсан, 1302 буюу 13.4 хувь нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон бусад хууль, тогтоомж зөрчсөн, 25 буюу 0.2 хувь нь өмч хөрөнгө үрэгдүүлсэн, 16 буюу 0.01 хувь цалин тэтгэвэр, тэтгэмж буруу олгосон 595 буюу 5.9 хувь нь бусад өргөдөл, гомдол тус тус эзэлж байна¹.

Эндээс дүгнэхэд цагдаагийн алба хаагч хүнд сурталтай, харьцааны ёс зүй, соёлгүй, мэдлэг, мэргэжлийн ур чадвар хангалтгүй, шаардлагын хэмжээнд хүрдэггүй, шударга бус танил тал хардаг гэх мэт олон нийтийн үзэл бодол, хандлага буурахгүй байгаагаас үүдэлтэй цагдаагийн байгууллагын талаархи сөрөг мэдээлэл хэвлэл, мэдээллийн хэрэгслээр давтамжтай хэлбэрээр гарах үндэс болсоор байна. Нөгөө талаар нийгмийн ёс суртахууны үнэлэмж үлэмж доройтсон өнөө үед иргэдээс цагдаагийн алба хаагчдыг дорд үзэх, гүтгэх, доромжлох нь ердийн үзэгдэл болсоор байна.

Дээрхи үүссэн нөхцөл байдлууд нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд ил тод сурталчлах, гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажилд олон нийтийн дэмжлэг туслалцааг өргөнөөр авах зайлшгүй шаардлага бий болсныг харуулж байгаа хэрэг бөгөөд үүнд хэвлэл, мэдээллийн хэрэгслийн үүрэг асар их юм. Энэ нь цагдаагийн

байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах зайлшгүй шаардлага бий болсныг нотолж байгаа хэрэг бөгөөд цаашид энэ чиглэлээр судалгаанд суурилсан, бодит ажлыг хэрэгжүүлэх шаардлага байгаа нь энэхүү сэдвийг сонгох хэрэгцээ шаардлага, үндэслэлийг бий болгож байна гэж үзлээ.

Нэг. Цагдаагийн байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгслийн хамтын ажиллагааг сайжруулах арга зам

Цагдаагийн байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллагын хамтын ажиллагаа зохих түвшинд, олон талт үйл ажиллагааг байнга тасралтгүй явуулж байгаа ч түүнийг сайжруулахад дараах хэд хэдэн чиглэлээр тодорхой үр бүтээлтэй ажиллах зайлшгүй шаардлага байгаа нь энэхүү судалгааны ажлын үр дүнгээс харагдаж байна. Үүнд:

1. Цагдаагийн албаны тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.7 дахь хэсэгт “Цагдаагийн байгууллага зохих сургалтад хамрагдаж тэнцсэн хэвлэл, мэдээллийн байгууллагын ажилтныг цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг сурвалжлах, мэдээлэх үүрэгтэйгээр тусгайлан томилж хамтран ажиллана”² гэж заасан байдаг.

¹ Цагдаагийн ерөнхий газрын Дотоод хяналт шалгалт, аюулгүй байдлын газар. Иргэд, байгууллагаас цагдаагийн байгууллагын

алба хаагчтай холбоотой ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт. 2021-2024 он.

² Цагдаагийн албаны тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2017. №8.

Өнөөдөр хэвлэл, мэдээллийн хэрэгслээр гэмт хэрэг үйлдэж байгаа болон үйлдсэн тухай эх сурвалж нь тодорхой бус, бодит баримт нотолгоонд түшиглээгүй, зөвхөн олон нийтийн анхаарал татахуйц зорилго агуулсан олон тооны мэдээлэл нийтлэгддэг ч тэдгээрийн үнэн зөв бодит байдлыг шалгаж, тогтоох эрх зүйн зохицуулалт байхгүй байна.

Түүнчлэн Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль (шинэчилсэн найруулга) -ийн 32 дугаар зүйлийн 32.7-д “шүүхээр гэм буруутай нь нотлогдоогүй байхад хэнийг ч гэм буруутай гэж хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлэхийг хориглоно¹” мөн Улсын дээд шүүхийн тайлбарт “харин хууль мэдэхгүй явдал нь хүндэтгэн үзэх шалтгаан болдоггүй” гэж тус тус заасан бөгөөд энэ ч утгаар хэвлэл, мэдээллийн хэрэгсэл нь өөрийн нийтэлж, нэвтрүүлж байгаа зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээх учир хуулийн агуулгыг уншаагүй, судлаагүй, тухайн мэдээллийг ямар эх сурвалжаас авсан болох нь тодорхой бус байдал нь хүндэтгэн үзэх шалтгаан болохгүй гэдгийг сурвалжлагч, сэтгүүлчдэд сайтар ойлгуулах, энэ талаар сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах шаардлага бий болжээ.

Хуулийн энэхүү заалтын хүрээнд өнөөдөр зохих сургалтад хамрагдаад тэнцсэн, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг сурвалжлах, мэдээлэх чиг үүрэгтэйгээр тусгайлан томилогдсон

хэвлэл, мэдээллийн байгууллагын ажилтан байхгүй байна. Иймд цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, үйл ажиллагааг олон нийтэд таниулан сурталчлах, гэмт хэрэгтэй тэмцэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх зорилго чиглэлээр хэвлэл, мэдээллийн байгууллагатай хамтран ажиллаж зохих сургалтад хамрагдсан ажилтныг томилон ажиллуулах нь зүйтэй байна.

Түүнчлэн Цагдаагийн албаны тухай хуулийн 96 дугаар зүйлийн 96.3-д “Иргэнийг баривчилсан, албадан саатуулсан, захиргааны хариуцлага хүлээлгэсэн тухай цагдаагийн байгууллагаас хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлсний дараа уг ажиллагаа үндэслэлгүй болох нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр нотлогдвол цагдаагийн байгууллага 10 хоногийн дотор хэвлэл мэдээллийн хэрэгслээр залруулга хийх үүрэгтэй” гэж заасан. Гэтэл зарим тохиолдолд энэ төрлийн залруулга төдийлөн хийгдэхгүй байгаагаас хүний эрх зөрчигдөх, цаашлаад нэр хүндэд сөргөөр нөлөөлөх нөхцөл байдал нийгэмд үүсч болзошгүй байгаад дүгнэлт хийж, хуулийн заалтыг хэрэгжүүлэн ажиллахад анхаарах шаардлагатай байна.

2. Эрх зүйн орчинг боловсронгуй болгох замаар сурвалжлагч, сэтгүүлчийн ёс зүй, нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх, эрэн сурвалжлах сэтгүүл зүйн бодит

¹ Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль (шинэчилсэн найруулга). Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2019. №42.

байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчлийн талаархи үнэн зөв мэдээ, мэдээллийг олон нийтэд шуурхай хүргэхэд чиглэсэн бодлогын шинжтэй, цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

➤ Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль¹-ийн 4 дүгээр зүйлд зааснаар төрийн байгууллага хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхыг хориглох учраас телевиз, радио, сэтгүүл, сонинтой байх хууль зүйн үндэслэлгүй байна. Өнөөдөр бодит байдал дээр хэвлэл мэдээллийн хэрэгслээр хохирогч, эд зүйл, онц ноцтой гэмт хэрэгтэнг эрэн сурвалжлах, хойшлуулшгүй мэдээллийг үнэ төлбөргүйгээр нийтэлж, нэвтрүүлж байгаа боловч гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлийн мэдээллийг төлбөртэйгээр нийтэлж байна. Төлбөрийн асуудал цагдаагийн байгууллагад хүндрэлтэй тусдаг бөгөөд ЦЕГ-ын Хэвлэл мэдээллийн төвийн хувьд өөрсдөө “зохицуулалт” хийж ирсэн нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, ухуулга, сурталчилгааны ажил хангалтгүй явагдаж байгааг харуулж байна. Түүнчлэн Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд

“тухайн жилд шүүхийн шийдвэр биелүүлэх, замын хөдөлгөөний болон хэв журмын зөрчлийг арилгах чиглэлээр улсын орлого болгосон, торгох ял ногдуулж төсөвт тушаасан мөнгөний 40 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулан дараагийн жилийн орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ” гэсэн заалт төдийлөн үр дүнтэй хэрэгжихгүй байна. Иймд хуулийн энэхүү заалтыг хэрэгжүүлэхэд төв, орон нутгийн удирдлагын байгууллага онцгой анхаарч гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн мэдээ, мэдээллийг олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүргэхэд хамтарч ажиллах, төлбөрийн асуудлыг шийдвэрлэхэд бодит туслалцаа, дэмжлэг үзүүлэх шаардлага бий болсон байна.

➤ Прокурорын байгууллагатай хамтран гэмт хэрэгтэй тэмцэх, ялангуяа урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг сурталчилсан хэлбэрээр тогтмол хэвлэл гаргах, эсхүл холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах замаар эрх зүйн орчинг бий болгох шаардлагатай байна.

➤ Монголын сэтгүүл зүйн салбарт “эрэн сурвалжлах сэтгүүл зүй”²

¹ Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль. 4 дүгээр зүйл. Төрийн байгууллага өөрийн мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхыг хориглоно. Төрийн мэдээлэл эмхэтгэл. 1998. №10.

² Томас Манн тэргүүтэй АНУ-ын зохиолчид эрэн сурвалжлах сэтгүүл зүйн үндсийг тавьсан гэдэг бол зарим судлаачид АНУ-ын Вотергейтийн хэрэг буюу 1970-аад оноос эрэн сурвалжлах сэтгүүл зүй хөгжсөн гэж үздэг. 1976 оны АНУ-ын ерөнхийлөгчийн

сонгуулийн үеэр Georgia мужид сонгуулийн сурталчилгааны үеэр “Хэвлэл мэдээллийн хэрэгсэл бол авлигачдын хууль бус үйлдлүүдийг нийтэд ил болгон, тэдний бусармаг ажиллагааг таслан зогсоох хүчирхэг хэрэгсэл мөн” гэж АНУ-ын 39 дэх ерөнхийлөгч, 2002 оны Нобелын энх тайвны шагналт Jimmy Carter хэлж эрэн сурвалжлах сэтгүүл зүйн хууль зүйн учир холбогдол, мөн чанарыг анхлан тодорхойлжээ.

гэсэн нэр томъёо хүчтэй түрэн орж ирэх болсон ч Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.13. дахь хэсэгт “... хуульд заасан үндэслэл журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгөх, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно” гэж заасан нь Монгол Улсад эрэн сурвалжлах чиглэлээр сэтгүүлч ажиллах, цаашлаад энэхүү харилцааг зохицуулсан салбар хууль байхгүйгээс сэтгүүлч, сурвалжлагчийн эрх зүйн орчин өнөөг хүртэл бүрдээгүй байна.

1963 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 113 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “хэвлэлд нийтлэгдсэн мэдээлэл”-ийг эрүүгийн хэрэг үүсгэх үндэслэлийн нэг төрөл болгон хуульчилсан байсныг 1990 оноос хойш нийгэм эдийн засгийн байдал, хэвлэлийн эрх чөлөө, сэтгүүлчийн ёс зүйн болон бусад хүчин зүйлийн улмаас 2002 оны 09 дүгээр сарын 1-ний өдрөөс үйлчилсэн шинэ Эрүүгийн байцаан шийтгэх хуулиас хассан. Энэ нь иргэн, албан тушаалтан гэмт хэргийн тухай гомдол, мэдээллийг эрх бүхий албан тушаалтанд албан ёсоор хандаагүй тохиолдолд хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд нийтлэгдсэн материалыг шалгах хууль эрх зүйн үндэслэлгүй болгосон юм.

Иймд сэтгүүлчийн ажлын үр дүн, үйл ажиллагааг улам бүр хуульд нийцсэн байх шаардлагыг нөхцөлдүүлэхийн тулд Эрүүгийн байцаан шийтгэх хуульд хууль зүйн техникийн үүднээс “үндэслэл”-ийг “шалтгаан” болгож залруулан хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтлэгдсэн мэдээллийг эрүүгийн хэрэг үүсгэх шалтгаанд нэмэлтээр хуульчлах шаардлагатай байна.

➤ “Олон нийтийн радио, телевизийн тухай хууль ¹”-ийн 34 дүгээр зүйлийн 34.2. дахь хэсэгт “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийтийн ашиг сонирхол хөндөгдсөн гэж шүүх ил болгохоос бусад тохиолдолд ОНРТ-ийн ажилтан мэдээллийн эх сурвалжийг нууцлах эрхтэй” гэж заасан нь дараах агуулгыг илэрхийлж байна.Үүнд:

- Зөвхөн олон нийтийн радио телевизийн ажилтанд хамаарах;
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх түүнчлэн нийтийн эрх ашиг сонирхол хөндөгдсөн гэж зөвхөн шүүхэд эх сурвалжаа илчлэх.

Сэтгүүлчийн эрэн сурвалжлах үйл ажиллагааны үр дүнд цуглуулсан баримт сэлт, мэдээлэл, түүний эх сурвалж болох гэрч, хохирогчийг заалгах, шаардлагатай тохиолдолд сэтгүүлчийг гэрчээр байцаан

¹ Олон нийтийн радио, телевизийн тухай хууль. 34 дүгээр зүйл. Мэдээлэл олж авах, мэдээллийн эх сурвалжийг нууцлах.

34.1. Олон нийтийн радио, телевизийн ажилтан төр, байгууллага болон хувь хүний нууцтай холбоотойгоос бусад мэдээллийг олж авах, нийтийн хүртээл болгох эрхтэй.

34.2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийтийн ашиг сонирхол хөндөгдсөн гэж шүүх үзэж ил болгосноос бусад тохиолдолд олон нийтийн радио, телевизийн ажилтан мэдээллийн эрх сурвалжийг нууцлах эрхтэй. Цахим эх сурвалж, холбоос: <http://www.legalinfo.mn/law/details/424>

мэдүүлгийг нотлох баримтын хэмжээнд үнэлнэ. Сэтгүүлч гэрчээр байцаагдахаас татгалзвал гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох үүргээ биелүүлж буй мөрдөн байцаагчийн нотлох баримтыг цуглуулах ажиллагаанд саад учруулж байна гэж үзэн Эрүүгийн хуульд заасан “гэрч мэдүүлэг өгөхөөс санаатайгаар зайлсхийх, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд саад учруулах” гэмт хэргийн шинжийг агуулсан үйлдэл болно¹.

Эрэн сурвалжлах сэтгүүлчийн үйл ажиллагааны явцад олж авсан баримт сэлт мэдээлэл нь дээр дурдсанчлан эрүүгийн хэрэг үүсгэх шалтгаан болохгүй бөгөөд улмаар Эрүүгийн байцаан шийтгэх хуульд зааснаар нотлох баримтыг гагцхүү мөрдөн шалгах ажиллагааг хэрэгжүүлэгч цуглуулах учраас энэ хуулийн 79 дүгээр зүйлийн 79.4. дэх хэсэг “нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх талаар хуульд заасан журмыг баримтлаагүй буюу зөрчсөн бол эдгээр нь нотлох чадвараа алдах бөгөөд шүүхийн шийдвэрийн үндэслэл болохгүй” гэж зааснаар сэтгүүлчийн цуглуулсан баримт, сэлт материал нь нотлох баримт болох хууль зүйн үндэслэлгүй байна. Гэвч “Хэвлэл, мэдээллийн эрх чөлөөний тухай хууль”-д “хэвлэл, мэдээллийн хэрэгсэл нь өөрийн нийтэлж, нэвтрүүлж байгаа

зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээнэ” гэж заасан учраас хэвлэл мэдээллийн ажилтан хууль зүйн хариуцлага хүлээлгэхээс чөлөөлөгдөх үндэслэлгүй байна. Энэ мэт **хоорондын утга агуулга, зохицуулалт нь уялдаа холбоогүй байгаа хуулийн заалтыг нэг мөр болгож өөрчлөх, цэгцлэх** шаардлага бий болсон байна.

3. Цагдаагийн байгууллага, алба хаагчдын үйл ажиллагааны талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлсэн болон иргэд, байгууллагаас ирүүлсэн сөрөг мэдээлэл, гомдол, бүрт ач холбогдол өгч бодит байдлыг шалгаж тогтоох, иргэд, олон нийтэд чиглэсэн мэдээлэл, сурталчилгааны PR-ийн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх.

ЦЕГ-ын даргын 2006 оны 618 дугаар тушаалаар Хэвлэл мэдээллийн төвийг байгуулж, цагдаагийн байгууллагын бодлого, үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр иргэд, олон нийтэд сурталчлан, таниулах чиг үүрэгтэй ажиллаж байгаа боловч цагдаагийн зарим алба хаагчаас хэвлэл мэдээллийн хэрэгслээр өөрийн шалгаж байгаа эрүүгийн хэрэг, ажил үүргийнхээ талаар дур мэдэн мэдээ, мэдээлэл, ярилцлага өгөх, хэвлэн нийтлэх байдал түгээмэл болсон нь цагдаагийн байгууллагын зорилт, бодлого, шийдвэрийг олон нийтэд үнэн зөв, бодитоор хүргэхэд зарим талаар

¹ “Глоб Интернэшнл” ТББ 2012-2014 онд нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон бусад хэлбэрээр гутаасан иргэний хэрэг маргаан болон бусдыг гүтгэсэн, доромжилсон эрүүгийн хэргийг шүүхээр эцэслэн

шийдвэрлэсэн байдлыг судласан. Нийт 154 хэрэг шүүхээр шийдвэрлэгдсэнээс 125 нь иргэний, 29 нь эрүүгийн хэрэг байжээ. 125 иргэний хэргээс 57-д нь сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгслийг хариуцагчаар татсан байна.

сөргөөр нөлөөлөх болсон нь судалгааны ажлын явцад ажиглагдаж байна.

Түүнчлэн цагдаагийн байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгслийн уламжлалт харилцаанд тулгуурлан цаашид өргөн хүрээнд хамтран ажиллах, нийтлэл нэвтрүүлгийн бодлогоо шинэчлэх зайлшгүй шаардлага бий болсон.

Судалгаагаар Монгол Улсын хэмжээнд 135 сонин, 99 сэтгүүл, 90 радио, 136 телевиз, 92 вэб сайт тогтмол үйл ажиллагаа явуулж улмаар телевиз, сонин, радиог нэгтгэсэн “Мультмедиа групп”, цахим сэтгүүл зүй эрчимтэй хөгжиж байна.

Монголын хэвлэл мэдээллийн хэрэгслийн системийг бүрдүүлэгч энэ томоохон орон зайд цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг гол төлөв сөрөг талаас нь мэдээлэх явдал байсаар байна. Цагдаагийн байгууллага нээлттэй үйл ажиллагаа явуулж, мэдээллийг олон нийтэд хүрэхүйц байлгаж байвал тэдний хооронд ямар нэгэн үл ойлголцох асуудал гарах нь багасч нийгэмд хэдий чинээ нээлттэй

нэвтрүүлгийг бодлогын чанартай нэвтрүүлэх нь чухал гэж үзэж байна.

Хүснэгт 1.

Хэвлэл, мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах нэвтрүүлгийн төрөл.

д/д	Нэвтрүүлгийн нэр	Нэвтрүүлгийн агуулга
1.	Хот амгалан байна уу	Цаг үеийн мэдээлэл тодруулга сэрэмжлүүлэг.
2.	Амрыг эрье	Цагдаагийн ажил үйлс, алба хаагчийн нийгмийн баталгаа, тулгамдсан асуудал, олон нийт-цагдаагийн хамтын ажиллагаа, албаны нэр хүнд, бахархал.
3.	Халуун цэг	Гэмт хэрэг ихээр үйлдэгдэн гарах цэг, олон нийтийн үйлчилгээ, үзвэрийн газар, зах, худалдааны төв зэрэг газраас сэтгүүлчтэй хамтран бэлтгэсэн сурвалжлага.

ил тод байна, төдий чинээ мэдээлэл олон нийтэд хүрч байгаа гэсэн үг. Мэдээллийн ийм асар том урсгал нь хамгийн дуулгавартай томоотой иргэнийг ч болж буй бүх үйл явдлын гадна байлгадаггүй байна.

Энэ байдлаас дүгнэлт хийж цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг иргэд, олон нийтэд хүртээмжтэй зөв талаас нь сурталчлах, улмаар гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд тэдний дэмжлэг тусалцааг өргөнөөр авах, албаны нэр хүндийг дээшлүүлэхэд чиглэсэн PR-ийн хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага бий болсон байна.

PR-ийн хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх ажлын хүрээнд олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон жил уламжлал байдлаар бэлтгэгдэж ирсэн “Цагдаагийн газраас мэдээлж байна”, “Хуулийн цаг”, “Шуурхай мэдээ”, “102 мэдээлж байна” гэх мэт хатуу нэршилтэй нэвтрүүлгийн агуулга, хэлбэрээс аль болох татгалзаж дараах

4.	Харих болоогүй аав	Цагдаагийн алба хаагчийн ар гэр, амьдрал, цагдаагийн албаны бахархал, хүндрэл бэрхшээл, тангарагтаа үнэнч зүтгэж байгаа алба хаагчийн нэр хүндийг өндөрт өргөх, олон нийтэд сурталчлах.
5.	Сумын цагдаагийн нэг өдөр	Баримтат уран сайхны нэвтрүүлэг. Хязгаар нутагт албан үүргээ гүйцэтгэж байгаа алба хаагчийн ажил, амьдрал, өдөр тутмын ажлыг онцлог нөхцөл байдал, хангамж зэрэг бодит байдлыг олон нийтэд хүргэх.
6.	Баярлалаа	Иргэд, олон нийтээс талархал дэвшүүлсэн бодит ажлын талаархи баримтат сурвалжлага.

4. Цагдаагийн байгууллагаас иргэд, олон нийт, түүнчлэн цагдаагийн алба хаагчдад мэдээ, мэдээллийг хүртээмжтэй түгээх, эргэх холбоо үүсгэх, тэдний дунд эерэг харьцаа, итгэлийг бий болгох, цагдаагийн байгууллагын нэр хүндийг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг тогтмол явуулах. Үүнд:

➤ **Цагдаагийн алба хаагч бүр мэдээлэл тээгч.** Цагдаагийн нэг алба хаагчийн гаргасан хууль бус алдааг иргэд олон тоон дээр асуудлыг авч үзэн улмаар уг гаргасан алдааг цагдаагийн нийт алба хаагч бүрт хамааралтай мэтээр олон нийтийн мэдээллийн хэрэгслээр түгээдэг. Иймд алба хаагч бүрийг цагдаагийн байгууллага, албаны нэр хүндийг өргөх, мэдээлэл түгээгч бичил эд эс гэж үзэн тэдэнд энэ талаар ойлгуулан ухамсарлуулах нь зүйтэй байна. Жишээ нь: алба хаагч албаны дүрэмт хувцастай үед зам гарахдаа заавал ногоон гэрлийг хүлээх, хувийн унаатай хөдөлгөөнд оролцож байх үедээ ч замын хөдөлгөөний дүрмийг чанд сахих, олон нийтийн газар биеэ зөв авч явах талаар яриа,

таниулга, сургалт хэлбэрээр эхлүүлж болно.

➤ **Мэдээлэл тээгч мэдээлэлтэй байх.** Судалгаанд хамрагдсан алба хаагчийн 30 орчим орчим нь “цагдаа шинэчлэгдэж байна уу” гэсэн асуултад “мэдэхгүй” гэснээс үзэхэд мэдээлэл тээгч өөрөө мэдээллээр дутмаг байгааг илэрхийлж байна. Аливаа байгууллагын шинэчлэл, өөрчлөлтийг удирдагч хийх боловч хэрэгжүүлэгч нь доод албан тушаалтан нь байдаг тул хамгийн түрүүнд тэд шинэчлэлт, өөрчлөлтийг хүсэх, мэдрэх, ойлгох нь чухал. Жишээ нь: Цагдаагийн албаны тухай хууль болон бусад холбогдох хуульд нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хэсэгт томилогдон ажиллаж байгаа алба хаагч бүр алба хаагч нарын дунд мэдээлэл түгээж болно. Үр дүнд нь алба хаагч нарын талаас багагүй хувь нь “мэдээллийг хөндлөнгийн хүнээс гэнэт сонсдог ¹” байдал өөрчлөгдөн шинэчлэлд бэлэн байх болно.

➤ **Мэдээлэл тээгчийг бэлтгэх.** Энэ ажлын хүрээнд хэсгийн байцаагч, мөрдөн байцаагч зэрэг зарим алба хаагчийг цагдаагийн байгууллагын

¹ Аригүмедиа. Богино хугацааны мэдээлэл харилцааны стратеги. – Уб., 2014.

өглөөний рапортнаас (гэмт хэрэг, зөрчлийн талаархи хоногийн мэдээний танилцуулга) чөлөөлөх. Жишээ нь: ахмад ажилтан, цагдаагийн хурандаа Д.Алтангэрэл өгүүлэхдээ “УМБГ-ын даргаар ажиллаж байхдаа мөрдөн байцаагч нарыг рапортнаас чөлөөлж билээ. Учир нь тухайн газар, хэлтсийн рапорт дээр гэмт хэрэг, зөрчлийн тухай ярихаасаа илүүтэй үр дүнгүй их хуралддаг тул өглөө тэр хүнээс мэдүүлэг авна, ингэж асууна гээд бодож байсан мөрдөн байцаагч хийх ажлаа мартчихдаг, гарч ирэнгүүтээ иргэдтэй маш амархан маргачих гээд байдаг” хэмээн дурсаж байна. Өөрөөр хэлбэл рапорт нь юугаар ч орлуулалшгүй ач холбогдолтой мэдээлэл түгээгч хэрэгсэл боловч хэт удаан үргэлжлэхээр мэдээлэл түгээгчийг цухалдуулдаг, нөгөө талдаа асуудлаа шийдүүлэхээр ирсэн иргэдийг чирэгдүүлдэг, хүлээлгэдэг зэргээр цагдаагийн байгууллагын дүр төрхийг муухай харагдуулах хүчин зүйл болж байна. Иймд рапортны хугацааг багасгах, зарим үед мэдээлэл түгээгчийг түүнээс чөлөөлөх арга хэмжээ авах нь зүйтэй.

➤ **Мэдээлэл тээгч хүчтэй байх.** Алба хаагч гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах үүргийг гүйцэтгэх үедээ үйл ажиллагаандаа **уян хатан** хандвал тухайн цагдаа, цаашлаад цагдаагийн байгууллагын хүчтэй, зоригтой, хүнлэг сэтгэлийг иргэдэд мэдрүүлж чадна. Тухайлбал, Абрахам Линкольн “дайснаа найз

болгох үед та тэднийг аль хэдийнээ устгачихсан гэсэн үг”, улмаар Махатма Ганди “сул дорой нэгэн хэзээ ч бусдыг уучилж чаддаггүй, гэвч уучлал нь таныг хүчирхэг байгааг илэрхийлнэ¹” гэж хэлснээс үзэхэд алба хаагч нар албан үүргээ гүйцэтгэхдээ зөрчил гаргасан иргэнийг шийтгэх, саатуулахыг урьтал болголгүй ажлаа сануулах арга хэмжээнээс эхлэх нь зүйтэй. Жишээ нь: **“иргэнд сануулга өгсөн тухай бүртгэлээр сан үүсгэх”** аргаар үүнийг хэрэгжүүлж болно. Энэ нь цагдаагийн байгууллагын бүх шатны удирдах албан тушаалтанд мөн хамаатай бөгөөд доод албан тушаалтнаа захирах, зандрах, загнах, арга хэмжээ авах бус уучилж, ярилцаж, ойлголцож байж хамтдаа амжилт гаргах үндэс болох юм.

➤ **Гар утас, таблетны аппликэйшныг бий болгох.** ЦЕГ-ын вэб хуудастай ижил төстэй цэс бүхий аппликэйшныг ашиглах нь алба хаагч нар болон иргэдэд мэдээлэл түргэн шуурхай хүрэх нэг суваг болно. Учир нь интернеттэй холбогдоогүй байсан ч мэдээлэл авч байх боломжийг гар утасны аппликэйшн олгох юм. Жишээ нь: ШШГЕГ 2014 онд иргэдэд мэдээлэл түгээх зорилгоор гар утасны аппликэйшн бүтээн ашиглаж байгаа бөгөөд иргэд хорих ангийн уулзалтын цагийг захиалах, хэдэн цаг уулзах боломжтойг мэдэх, хорих анги руу оруулахыг хориглосон эд зүйлийн жагсаалтыг харах боломжийг олгож үр дүнгээ өгч эхэлсэн байна. Үүнтэй адил

¹ Дайсны талаарх хэлц үгнүүд (Quotes About Enemies) Цахим эх сурвалж, холбоос:

<http://www.goodreads.com/quotes/tag/enemies>

цагдаагийн байгууллага гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, иргэд, олон нийтийн анхаарал сонор, сэрэмжийг дээшлүүлэх болон цаг үеийн шинжтэй бусад шуурхай мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх өргөн боломж нээгдэж, олон талын ач холбогдлыг бий болгоно.

➤ **Телевизийн нэвтрүүлгийн тоог нэмэгдүүлэх.** Иргэдийн 40 хувь нь телевизийг бусад мэдээллийн хэрэгслээс илүү үздэг болох нь судалгааны дүнгээс харагдсан. Иймд цагдаагийн алба хаагчийн ажил, амьдралыг харуулсан уран сайхны цуврал кино захиалж хийлгэх, улмаар телевизийн сувгаар нэвтрүүлж цагдаагийн албыг олон нийтэд сурталчлах ажлыг үргэлжлүүлэх нь зүйтэй. Түүнчлэн зохиолыг улсын хэмжээнд уралдаант шалгаруулалтын хэлбэрээр явуулах нь хамтын ажиллагааны бас нэгэн хэлбэр юм. Жишээ нь: 2011 онд нийтийн хүртээл болсон “Нар сарын зааг” кино нь цагдаагийн алба хаагчийн талаар эерэг сэтгэгдэл төрүүлж чадсан, олонд хүрсэн бүтээл болсон гэдгийг олон иргэд, цагдаагийн ахмад ажилтнууд, кино шүүмжлэгч нар үнэлсэн байна.

5. Цагдаагийн алба хаагч, түүн дотроо удирдах алба хаагчийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр ярилцлага, мэдээлэл өгөх ур чадварыг дээшлүүлэх, тэднийг өөрийгөө илэрхийлэх сургалтанд хамруулах.

Судалгаанаас харахад цагдаагийн удирдах албан тушаалтан, алба хаагчдаас хэвлэл мэдээллийн хэрэгслээр ярилцлага, мэдээлэл өгөхдөө логикийн /утгын/ алдаатай ярьдаг, бусдад өөрийгөө ойлгуулах, мэдээлэл түгээх чадвар сул байгаа нь ажиглагдсан байна.

Хэл ярианы соёл бол хүний оюуны соёлын толь бөгөөд өгүүлэгч этгээд хэл яриагаараа өөрийнхөө хэн болохыг харуулаад зогсохгүй, оюун ухааныхаа цар хүрээ, ёс суртахууны хэр хэмжээ, сэтгэхүйнхээ чадал тэнхээг илтгэн харуулдаг¹ байна. Хэл ярианы соёлын онолоор бол аливаа хүний яриа: зөв, оновчтой, товч, тодорхой, энгийн, цэвэр, баялаг, амьд, яруу байх шаардлагатай² байхаас гадна эрх зүйн харилцааны явцад хэл-ярианы дараах хэд хэдэн логик шалгуур тавигддаг. Үүнд:

Утга холбогдолтой байх.

“Харилцааны үндсэн бөгөөд анхдагч үе шат үг ба утга санаа тохирч байх явдал юм³”. Эрх зүйн харилцаанд оролцож буй хэн боловч утга холбогдол бүхий үг, ойлголт хэрэглэх учиртай юм. Эсрэг тохиолдолд “худал” яриа, “худал” сэтгэлгээ болно.

Жишээ 1. Мөрдөн байцаалтаар нотлогдох ёстой зүйлсийг бүх талаас нь шалгаад, холбогдох хүмүүсийг яллагдагчаар татсан⁴.

Энэ өгүүлбэрийн “мөрдөн байцаалтаар нотлогдох ёстой зүйлс”

¹ Э.Пүрэвжав. Монгол хэлний хэм хэмжээ. – УБ., 2004.

² С.Галсан. Хэл шинжлэл ба бусад. – УБ., 2007.

³ McInerney D.Q. Being logical. A guide to good thinking. New York. 2004. p. 13.

⁴ Е.Сарсай. Цагдаагийн ажилтан зэвсэг хэрэглэсэн нь тодорхой, гэхдээ хэн хүн буудсан нь тогтоогдоогүй. //Үнэн сонин.

гэсэн хэсэгт анхаарлаа хандуулвал мөрдөн байцаалтаар нотлогдох эсэх нь урьдаас тогтоогдсон, өөрөөр хэлбэл, “нотлогдох ёстой” эсвэл “нотлогдох ёсгүй” зүйл байдаг болж таарч байна. Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйд “нотолгооны зүйл” гэдэг ойлголт хэрэглэдэг. Тэр нь “уг хэргийг үнэн зөв шийдвэрлэхэд зайлшгүй тогтоох шаардлагатай нөхцөл байдлуудын нийлбэр юм¹”. Өөрөөр хэлбэл, нотлох шаардлагатай, нотолвол зохих байдлыг нотолгооны зүйл гэнэ. Жишээ нь: Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 80 дугаар зүйлд зааснаар “уг гэмт хэргийг хэн үйлдсэн бэ” гэдэг нь нотолвол зохих зүйл болно. Харин “уг гэмт хэргийг Болдбат гэдэг хүн үйлдсэн байх ёстой” гэх урьдаас төлөвлөгдсөн “нотлогдох ёстой зүйл” байх боломжгүй юм. Бодит байдал дээр гэмт хэргийг хэн үйлдсэн нь янз бүрийн шалтгааны улмаас нотлогдохгүй, тогтоогдохгүй ч байж болно.

Жишээ 2. Гэтэл харцагын сууж явсан машин хэвтээ тэмдэглэгээг харсаар байж зүүн тийш эргэх гээд байсан².

Энэ өгүүлбэрийн “харцагын сууж явсан машин хэвтээ тэмдэглэгээг харсаар байж” гэсэн хэсэгт анхаарлаа хандуулвал хэвтээ тэмдэглэгээг уг

машины жолооч биш, “харцага” ч биш, харин “харцагын сууж явсан машин” өөрөө харсан байна. Үйл явдлыг сэргээн ярьсан дээрх ярилцлагад дурьдагдаж буй ойлголтыг утга холбогдолтой гэж үзэхэд хүндрэлтэй бөгөөд хэрвээ уг асуудал мэдүүлэг, нотлох баримт зэрэг өөр төвшинд яригдвал энэ нь утга холбогдолгүй буюу “худал” үг гэж тооцогдоно.

Жишээ 3. Сүүлийн үед бага оврын микро, портер машинаар малыг бэлчээр дээрээс нь ачаад, машин дотроо мэргэжлийн түвшинд махалж, машиныхаа дугуй, номер дугаарыг солих тохиолдол илэрч байгаа учир хүний өөрийн гэлтгүй зөрчил гаргасан тээврийн хэрэгсэлд хариуцлага хүлээлгэдэг³.

Ярилцлагын сэдэв бүхэлдээ мал хулгайлах гэмт хэргийн талаар бөгөөд мөн энэ өгүүлбэр ч тэр тухай л юм. Энд “... машинаар малыг бэлчээр дээрээс нь ачаад” уу, эсвэл “...малыг бэлчээр дээрээс нь машинд ачаад” уу? эсвэл энд өргөгч, ачигч, крантай микро, портерийн тухай ярьж байгаа юм уу? Бас “мэргэжлийн түвшинд махлах” гэдгийг юу гэж ойлгох вэ?, “номер дугаар” гэж нэг зүйл үү, өөр өөр зүйл үү?, эсвэл холбоо үг юм уу? гэх зэрэг олон асуулт байгаа боловч эдгээрээс

2012.01.10. Ярилцсан М.Өнөржаргал. <http://www.unen.mn/content/6680.shtml?alias=unen>

¹ Б. Бат-Эрдэнэ. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй. – Уб., 2004.

² З.Батнаран. “Г.Намсрайжав харцага машинаасаа бууж ирээд үг дуугүй цохиод авсан” // Үнэн сонин. 2012.04.03. Ярилцсан Д.Мягмаржаргал.

<http://www.unen.mn/content/9715.shtml?alias=ulaanbaatar>

³ Б.Мөнхдорж. Мал хулгайлах гэмт бүлэглэлийг ченжүүд толгойлж байна. // Монцамэ. 2011 оны 06-р сарын 23-ны өдөр. Ярилцсан Н.Гантуяа. <http://sonin.info/2011/06/мал-хулгайлах-гэмт-бүлэглэлийг-ченжү/>

чухал нэг асуудал байна. Тэр нь “... зөрчил гаргасан тээврийн хэрэгсэлд хариуцлага хүлээлгэдэг” тухай яриа юм.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.1. дэх хэсэгт “эрүүгийн хариуцлагыг зөвхөн хувь хүнд хүлээлгэнэ” гэж заасан байдаг. Эрүүгийн хариуцлагыг хувь хүнээс өөр ямар нэг зүйлд, тухайлбал тээврийн хэрэгсэлд хүлээлгэх зохицуулалт өнөөдөр мөрдөгдөж байгаа хуульд байхгүй. Тийм учраас ярилцлага өгсөн хүний хэлсэн “зөрчил гаргасан тээврийн хэрэгсэл”, “... зөрчил гаргасан тээврийн хэрэгсэлд хариуцлага хүлээлгэх” гэдэг нь утга холбогдолгүй зүйл байна.

Нэгэн утгатай байх. Ойлголт утга холбогдолтой байхаас гадна тэр нь тодорхой хүрээнд өөрчлөгддөггүй байх ёстой. Аливаа ойлголт, сэдэв тухайн эргэцүүллийн хүрээнд хичнээн удаа давтагдахаас үл хамааран өөрөө өөртэйгөө тэнцүү байх ёстой гэсэн адилсалын хуулийг логикийн хамгийн энгийн бөгөөд суурь зарчим гэж үзэн $(a \equiv a)$ гэсэн логик томъёогоор илэрхийлдэг. Ямар нэг зүйлийн талаар a гэж хэлсэн бол тухайн эргэцүүллийн хүрээнд $\bar{a}$ (а биш) ойлголт, сэдэв ярьж болохгүй гэсэн санаа.

Харин ямар нэг A сэтгэлгээ B сэтгэлгээтэй тэнцүү байж болно. Энэ тохиолдолд B бол A -тай тэнцүү байна. Мөн B нь B -тэй тэнцүү байж болох

бөгөөд эдгээр тохиолдолд адилсалын хууль зөрчигдөхгүй.


Жишээ 1. Энэ хэргийн хувьд хохирогчид, яллагдагчид 2009 онд бүтэн жил гаруй хугацаанд хавтаст хэрэгтэй танилцсан.

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад “жил” гэсэн хугацааг хэрэглэх бөгөөд жилээр тоолоход уг хуулийн 96 дугаар зүйлийн 96.3. дугаар зүйлд зааснаар дараа оны тухайн сарын тухайн өдөр жил дуусдаг байна. Энэ жишээнд “жил” гэдэг ойлголтыг ердийн хэлний болон эрх зүйн тогтсон ойлголтын аль алинтай нь зөрчилтэй байдлаар хэрэглэжээ.

Зөрчилгүй байх. Өмнөх шаардлагыг хангаагүй бол хэл-ярианы явцад зөрчил гарцаагүй үүснэ. Ойлголт, сэдэв тухайн эргэцүүллийн хүрээнд, нэг цаг, нэг харилцаанд нэгэн утгатай биш байвал логик зөрчилд орно гэсэн үг. Зөрчилгүйн хууль $(a \wedge \bar{a})$, гуравдахийг үгүйсгэх хууль $(a \vee \bar{a})$ гэж нэрлэгддэг логик зарчимууд хэл-яриа болон сэтгэлгээ зөрчилгүй байх шаардлагыг хангахад тусалдаг.

Ямар нэг зүйлийн талаар нэгэн зэрэг a ба $\bar{a}$ (а биш) гэж ярьсан бол тэдгээр нь нэгэн зэрэг үнэн байж чадахгүй $((a \wedge \bar{a}))$ бөгөөд нэг нь заавал үнэн, нөгөө нь заавал худал байна $((a \vee \bar{a}))$.

Зураг 1.



Зураг дээр байгаа www.sonin.info/2011/10/ гэсэн хаягаар орж бүрэн эхээр нь олж үзэж болох юм. Энд хоёр өгүүлбэрийг доогуур нь зурж тэмдэглэсэн байна.

(1) “Торгуулийн мөнгө цагдаагийн халаасанд ордог гэсэн ойлголт ерөөсөө байхгүй” гэдэг хэллэгийг ($\bar{a}$) буюу а биш гэе.

(2) “Зөрчил гаргасан жолооч үнэхээр цагдаагийн халаасанд хийхийг хүсэхгүй л байгаа бол торгуулийн хуудсаа нэхэх ёстой шүү дээ” гэсэнд дараах хэд хэдэн мэдээлэл байна.

1) “Зөрчил гаргасан жолооч үнэхээр цагдаагийн халаасанд хийхийг хүсэхгүй л байгаа бол...” гэдэг нь “торгуулийн мөнгө цагдаагийн халаасанд ордог” (a) гэдэг хэллэгийг батлаж байна.

2) Мөн энэ хэллэг нь “торгуулийн мөнгө цагдаагийн халаасанд ордог гэсэн ойлголт ерөөсөө байхгүй” ($\bar{a}$) гэсэн хэллэгийг үгүйсгэж байна.

3) ($\bar{\bar{a}} \equiv a$) байх зарчимаар “Торгуулийн мөнгө цагдаагийн халаасанд ордог” гэсэн хэллэг үнэн байна.

“Торгуулийн мөнгө цагдаагийн халаасанд ордог”-ийн шалтгаан нь “зөрчил гаргасан жолооч торгуулийн хуудсаа нэхдэггүй” явдал болж байна.

Эндээс үзвэл ярилцлага өгч буй хүн нэг эргэцүүллийн хүрээнд нэг сэдвийн талаар зөрчилт утгатайгаар ярьсан нь илэрхий харагдаж байна. Логикийн үүднээс нэг эргэцүүллийн хүрээнд ($a \equiv a$) байх ёстой атал энэ тохиолдолд (a) ба ($\bar{a}$) нэгэн зэрэг яригдсан байна. Ийм учраас эдгээр хэллэгүүд нь нэгэн зэрэг үнэн байж чадахгүй ($\bar{a} \wedge \bar{a}$) буюу зөрчилгүйн зарчим ёсоор) тул аль нэг нь үнэн, аль нэг нь худал ($a \vee \bar{a}$) буюу гуравдахийг үгүйсгэх зарчим ёсоор) байх ёстой болно.

Мөн дашрамд дурьдахад, дээрх ярилцлагад хэрэглэсэн “торгуулийн мөнгө цагдаагийн халаасанд орох” гэдэг хэллэг хэлзүйн болон учир зүйн алдаатай байна. Мөнгө амьтай зүйл биш учраас ямар нэг зүйлрүү (жишээ нь, халаасанд) орох боломжгүй, харин халаасанд мөнгийг хийж болох. Тэгвэл цагдаагийн албан хаагч, эсвэл торгуулж байгаа хүн мөнгийг халаасруу хийнэ. Нөгөө талаас, “торгуулийн мөнгө цагдаагийн халаасанд ордог” ч гэсэн

бай, “торгуулийн мөнгө цагдаагийн халаасанд ордоггүй” ч гэсэн бай, ерөөсөө ямар нэгэн ойлголт байгаа болоод бид түүнийг эргэцүүллийн явцад хэрэглэдэг. Харин тэр ойлголт нь үнэн худал, зөв буруу байх нь өөр хэрэг. Тиймээс, “торгуулийн мөнгө цагдаагийн халаасанд ордог гэсэн ойлголт ерөөсөө байхгүй” гэж болохгүй юм.

Дүгнэлт

Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр түгсэн, дээр дурьдсан жишээнээс үзэхэд эрх зүйн харилцаанд оролцогчид хэл-ярианы элдэв алдааг түгээмэл гаргаж байгаад дүгнэлт хийж тодорхой арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллах шаардлага бий болсныг харуулж байна.

Хэвлэл мэдээллийн байгууллагад олон түмнийг нийтлэл, нэвтрүүлгийн тусламжтайгаар үнэн, бодитой мэдээллээр шуурхай, тасралтгүй хангах зорилго бүхий тогтмол хэвлэл, радио, телевиз, мэдээллийн агентлаг, баримтат кино, цахим хэвлэл зэрэг мэдээллийн суваг багтана. Хэвлэл мэдээллийн байгууллага нь тухайн үеийн нийгмийн оюун санааны хэрэгцээ шаардлагын илэрхийлэл байж олон түмний санаа бодолд нөлөөлөхүйц мэдээллээр хангагч оюуны болоод нийгмийн харилцааны чухал хэрэглэгдэхүүн юм.

Санал

Судалгааны ажлыг дүгнэж дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Цагдаагийн алба хаагч хуулийн үг, хэллэгийг оновчтой

хэрэглэх логик зарчмыг мэддэг байх, түүнийг өдөр тутам үйл ажиллагаандаа хэрэглэх чадварыг эзэмшүүлэх;

2. Хэвлэл мэдээллийн байгууллагуудын удирдлагатай урт хугацааны хамтын ажиллагааны гэрээ байгуулан хамтран ажиллах харилцааг өргөжүүлэх;

3. Олон нийтэд мэдээлэл түгээх хамгийн хүртээмжтэй сувгаар шалгарсан телевизтэй хамтран ажиллаж нэвтрүүлгийн найруулга, ур чадварыг дээшлүүлэх;

4. Цагдаагийн байгууллагын нэгж бүрт хэвлэл мэдээллийн ажилтны орон тоог бий болгож тэдний ур чадварыг дээшлүүлэх;

5. Олон нийтийн хамгийн ихээр хэрэглэдэг хэт богино долгионы радио нэвтрүүлгийг цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал, гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажилд өргөн ашиглах;

6. Цагдаагийн байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгслийн хамтын ажиллагааны хүрээнд “Мэдээлэл харилцааны стратеги, хөтөлбөр”-ийг боловсруулж техник, технологийн шинэчлэл хийх замаар үйл ажиллагааныхаа чадавхийг дээшлүүлэх;

7. “Олон нийтийн харилцаа болон мэдээлэл харилцааны сургалтын хөтөлбөр”-ийг боловсруулан алба хаагч бүрийн хэл ярианы болон мэдээлэл харилцаа холбооны мэдлэг ур чадварыг дээшлүүлэх;

8. Цагдаагийн байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгслийн хамтын

ажиллагааг өргөжүүлэн, мэдээлэл харилцааны бүтээгдэхүүний төрлийн олон талт хэлбэрийг бий болгож хамтран ажиллах;

9. Цагдаагийн байгууллага, алба хаагчдын үйл ажиллагааны талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлсэн болон иргэд, байгууллагаас ирүүлсэн сөрөг мэдээлэл, гомдол, бүрт ач холбогдол өгч бодит байдлыг шалгаж тогтоох, иргэд, олон нийтэд чиглэсэн мэдээлэл, сурталчилгааны PR-ийн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх зэрэг арга хэмжээг авах шаардлагатай байна.

Ашигласан материалын жагсаалт

- Хууль тогтоомж:

Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. 1992. №1.

Хөдөлмөрийн тухай хууль (2021)

- УИХ, ЗГ-ын тогтоол, бодлогын баримт бичиг:

1. Цагдаагийн ерөнхий газар. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам. – Уб., 2013 он

Цагдаагийн ерөнхий газар. Хэвлэл мэдээллийн байгууллагатай харилцах журам. код 242- Ном, сурах бичиг, гарын авлага:

Media Law. Хэвлэл, мэдээллийн хууль: гарын авлага. – Уб., 2010. 127 хуудас.

Г.Дэлэг. Д.Үржинбадам. Хэвлэлийн онол, дадлага. – Уб., 1984.

2. Максима судалгааны төв. Цагдаагийн байгууллагын үйл

ажиллагааны талаарх иргэд, алба хаагчдын дунд явуулсан судалгааны ажлын тайлан – Уб., 2008.

3. С.Баасанжав. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах арга зам. Магистрын судалгааны ажил. – Уб., 2015. 65 хуудас.

4. Философи, социологи эрхийн хүрээлэн. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны өнөөгийн байдал, боловсронгуй болгох чиглэл социологийн судалгааны тайлан. – Уб., 2008.

5. Аригүмедиа. Богино хугацааны мэдээлэл харилцааны стратеги. – Уб., 2014.

6. ЦЕГ, Судалгаа шинжилгээний Эс Ай Си Эй ХХК. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хэрэглэгчийн үнэлгээ хийсэн ажлын тайлан. – Уб., 2015.

7. ЦЕГ, Хууль зүйн үндэсний хүрээлэн. Цагдаагийн байгууллагын 2011 оны үйл ажиллагаанд хэрэглэгчдээс өгсөн үнэлгээ судалгааны тайлан. – Уб., 2022.

8. ЦЕГ-ын Дотоод хяналт, аюулгүй байдлын газар, Судалгаа, дүн шинжилгээний төв. Цагдаагийн алба хаагчдаас үйлдсэн гэмт хэрэг, зөрчил, харилцаа, ёс зүйн өнөөгийн байдал” судалгааны ажлын тайлан. – Уб., 2016.

9. ЦЕГ-ын Судалгаа, дүн шинжилгээний төв. Гэмт хэрэг, зөрчлийн улмаас хохирсон цагдаагийн алба хаагчдын өнөөгийн байдал. – Уб., 2015.